



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Сургалтанд хамруулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Журам батлах тухай” 119 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2016 оны А/76-р тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн хурлын шийдвэр, мөн журмын 3 дугаар зүйлийн 3.2, 3.8 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны “Сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай” А/111-р тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны “Төгсөлтийн дараах гадаад сургалтын тэрүүлэх чиглэл батлах тухай” А/169-р тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.БНЭУ-ын “Фортис” эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах суралцагчдын нэрс, мэргэжлийн чиглэл, хугацааг хавсралтаар баталсугай.

2.Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтад шаардагдах зардлыг холбогдох зардлын зүйл ангиас тооцон гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Очир/-д зөвшөөрсүгэй.

3.Сургалтын явцын тайланг сургалт эхэлснээс 14 хоногт багтаан бичгээр, суралцаж ирээд төгсөлтийн тайланг 7 хоногийн дотор, үр дүнгийн тайланг 3 дах сард Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны дарга /Д.Уранчимэг/-д, байгууллагын удирдлагад амаар болон бичгээр ирүүлэхийг багийн ахлагч /Ж.Эрдэнэсүрэн /-д тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн албаны дарга /Л.Оюунчимэг/-д даалгасугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



420836

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий
захирлын 2017 оны 01 сарын 02 өдрийн
А/01 дугаар тушаалын хавсралт



СУРАЛЦАГЧДЫН НЭРС, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Овог нэрс	Харьяа байгууллага	Суралцах чиглэл	Хугацаа
1.	Жамбалсүрэнгийн Эрдэнэсүрэн	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Зүрхний мэс засал	2017.01.07- 2017.02.03
2.	Энхбаатарын Баттөр	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Зүрхний мэс засал	2017.01.07- 2017.02.03
3.	Сүхбаатарын Ванчиндорж	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхдийн зүрхний мэс засал	2017.01.07- 2017.02.03
4.	Жамсранжавын Дашдорж	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхдийн зүрхний мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг	2017.01.07- 2017.02.03

БНЭУ-ЫН ФОРТИС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
СУРГАЛТЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН АЖЛЫН
ХЭСГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Он, сар, өдөр: 2016 оны 12 сарын 15

Хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүд:

1. Д.Уранчимэг, Ажлын хэсгийн дарга /ЭМХА-ны дарга/
2. Г.Батцэцэг, Ажлын хэсгийн гишүүн /Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүний нөөцийн мэргэжилтэн/
3. Х.Ганцэцэг, Ажлын хэсгийн нарийн бичиг /ЭМХА-ны гадаад сургалт, удирдах, гүйцэтгэх ажилтны сургалт хариуцсан мэргэжилтэн/
4. Б.Туяа, Ажлын хэсгийн гишүүн /ЭМЯ-ны гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн/-УИХ-ын байнгын хорооны хуралд асуудал танилцуулах ажилтай тул ирээгүй

Хурлын явц:

Х.Ганцэцэг: Энэ удаагийн сургалт БНЭУ-ын Фортис эрүүл мэндийн төвд зүрхний мэс засал, зүрхний мэс заслын үеийн мэдээгүйжүүлгийн чиглэлээр 1 сарын хугацаагаар зохион байгуулагдана. Сонгон шалгаруулалтад нийт 8 эмч мэргэжилтэн бичиг баримтаа бүрдүүлэн ирүүлснийг та бүхэнд урьдчилан танилцуулан үнэлүүлэхээр хүргүүлсэн байгаа.

Д.Уранчимэг: 1-р шатанд тэнцсэн 6 эмч мэргэжилтэнг өнөөдөр сонгон шалгаруулалтад дуудан ярилцлаа. Англи хэлний бичгийн болон ярианы чадварыг үнэлэн, өөрийн мэргэжлийн ирээдүйн төсөөлөл, төлөвлөгөөний талаар ярилцсаны үндсэн дээр ЭХЭМҮТ-ийн хүүхдийн клиникийн их эмч С.Ванчиндорж, Ж.Дашдорж, УГТЭ-ийн зүрхний мэс заслын эмч Ж.Эрдэнэсүрэн, УНТЭ-ийн зүрхний тасгийн их эмч Э.Баттөр нарыг сургалтад хамруулах саналтай байна.

Г.Батцэцэг: Ярилцлагад оролцсон эмч нараас онооны дарааллаар дээрх 4 эмчийг сургалтад хамруулах саналтай байна.

Х.Ганцэцэг: Хэлний мэдлэг, цаашдын зорилго зэргийг харгалзан үзэхэд нэр дэрдагдсан 4 эмч онооны хувьд илүү байгаа тул дэмжиж байна.

Ажлын хэсгийн хурлын шийдвэр:

Д.Уранчимэг:

1. Хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо, саналыг үндэслэн ЭХЭМҮТ-ийн хүүхдийн клиникийн их эмч С.Ванчиндорж, Ж.Дашдорж, УГТЭ-ийн зүрхний мэс заслын эмч Ж.Эрдэнэсүрэн, УНТЭ-ийн зүрхний тасгийн их эмч Э.Баттөр нарыг сургалтад хамруулахыг ажлын хэсгийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ. Иймд БНЭУ-ын Фортис эрүүл мэндийн төвд зохион байгуулагдах зүрхний мэс засал, зүрхний мэс заслын мэдээгүйжүүлгийн мэргэжил дээшлүүлэх сургалтад нэр дурдагдсан 4 эмчийг суралцуулья.


2. Суралцах эмч нарын виз хүсэх, тийз захиалах, тушаал боловсруулан батлуулах, төрийн сангийн гурвалсан гэрээ байгуулан сургалтыг зохион байгуулж ажиллахыг ЭМХА-ны гадаад сургалт хариуцсан мэргэжилтэн Х.Ганцэцэг хариуцна.

Шийдвэрийг зөвшөөрсөн:


Ажлын хэсгийн дарга:

Ажлын хэсгийн гишүүн:


Ажлын хэсгийн нарийн бичиг:



Д.Уранчимэг




Г.Батцэцэг



Х.Ганцэцэг

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



Х.Ганцэцэг

Сонгон шалгаруулалтын нэгдсэн дүн

БНЗУ-Фортис эрүүл мэндийн төв

№	Овог нэр	Мэргэжил дээшлүүлэх чиглэл	Харьяа байгууллага	Үнэлгээ			Дундаж оноо
				Д.Уранчимэг	Г.Батцэцэг	Х.Ганцэцэг	
1	Ө.Ганчимэг	Зүрх судасны эмч	УГТЭ-ийн зүрхний тасгийн эмч	Ирээгүй	Ирээгүй	Ирээгүй	Ирээгүй
2	Э.Баттөр	Мэс заслын эмч	УНТЭ-ийн мэс заслын эмч	90	98	90	92.6
3	Ж.Эрдэнэсүрэн	Зүрхний мэс заслын эмч	УГТЭ-ийн зүрхний мэс заслын эмч	92	98	93	94.3
4	С.Баяраа	Нөхөн сэргээхийн их эмч	Увс НЭ	Ирээгүй	Ирээгүй	Ирээгүй	Ирээгүй
5	Д.Оюунжаргал	Гэмтлийн мэс заслын эмч	ГССҮТ	83	80	85	82.6
6	Энхтүвшин	Гэмтлийн мэс заслын эмч	ГССҮТ	81	75	82	79.3
7	Ж.Дашдорж	Хүүхдийн мэдээгүйжүүлэгч эмч	ЭХЭМҮТ	94	95	90	93
8	С.Ванчиндорж	Хүүхдийн зүрхний мэс заслын эмч	ЭХЭМҮТ	94	94	92	93.3

Үнэлгээ хийсэн:

Handwritten signatures

Д.Уранчимэг /ЭМХА-ны дарга/
Х.Ганцэцэг /ЭМХА-ны мэргэжилтэн/
Г.Батцэцэг/ЗААА, Хүний нөөцийн ажилтан/